

Биелээгүй амлалт: Оюутолгойн үйл ажиллагаанд гарсан алдаа, дутагдал ба малчдын амьжиргаа, усны төлөөх тэмцэл

2024 оны 9 дүгээр сард Монгол Улсад хийсэн томилолтын тайлан

Говийн газар шороо ТББ, Малчдын төлөөлөгчдийн баг, ОТ Хяналт, Аккаунтэбилити Коунсел, Баруун өмнөдийн судалгаа мэдээллийн төвөөс хамтран гаргав.

Хураангуй

Монголын өмнийн говийн нутаг дахь зэс-алтны асар том уурхай болох Оюу Толгой (ОТ) уурхай ашиглалтад орсноосоо хойш нутгийн малчдид болон байгаль орчинд ноцтой нөлөөлж байна гэсэн шүүмжлэлд өртсөөр ирсэн. Уурхай тэлсэн дэд бүтцээс үүдэлтэйгээр малчдын ус, бэлчээрийн хүртээмж хомсдож, түүнийг арилгах арга замыг арав гаруй жилийн турш хайсаар ирсэн. Ийнхүү 2012, 2013 онд говийн малчид Нийцлийн зөвлөх омбудсман (CAO)-д албан ёсоор гомдол гаргаснаар 2017 онд Малчдын гомдлыг барагдуулах шинэлэг хоёр гэрээг байгуулсан түүхтэй. Эдгээр гэрээнүүдийг хэрэгжүүлснээр усны эх үүсвэрийг сэргээх, малчдын амьжиргааг дэмжих зэрэг чухал асуудлуудыг шийдвэрлэх зорилготой байв. Эхлэл ийнхүү өөдрөг байсан хэдий ч гэрээнд тусгагдсан амлалтуудын ихэнх нь биелээгүй хэвээр байгаа нь малчдад бэрхшээл, сорилтыг үргэлжлүүлэн бий болгосоор байна. Эдгээр сорилтууд дээр нэмээд ОТ-н Хаягдал хадгалах байгууламж (ХХБ) нь байгаль орчинд ихээхэн аюул учруулж байна. ХХБ-аас гарсан шүүрэлт, нэвчилт нь бэлчээрийн доройтлыг улам даамжруулж, эрүүл мэнд, байгаль орчинд ихээхэн эрсдэл учруулж, малчдын амь, амьжиргаагаа залгуулдаг эмзэг экосистемийг сүйтгэж байна.

2021 оны 11-р сард ХХБ-д хаягдал усны шүүрэлт цуглуулахтай¹ холбоотой байгаль орчинд нөлөөлөхүйц тохиолдол гарсныг ОТ албан ёсоор тодорхойлон хүлээн зөвшөөрсөн хэдий ч зөвхөн 2023 оны 10-р сарын сүүлээр л зээлдүүлэгчид Хаягдлын нэгдүгээр далангаас (ХД1) хаягдал ус шүүрснийг байгаль орчны осол² гэж ангилсан байдаг. Өмнийн говийн эрс тэс нөхцөлд аж төрж буй малчдын амьжиргаа нь бэлчээр, цэнгэг усны чанартай нягт холбоотой байдаг учир бэлчээр, усны чанарт сөргөөр нөлөөлж буй хаягдлын далангийн шүүрэлт ноцтой асуудал болоод байна. ХД-ийн шүүрэлт ОТ-н олборлолтын талбайн гадагш алдагдсанд гурван үндсэн шалтгаан бий. Нэгдүгээрт, Оюутолгой компани ХХБ-ийн зураг төслийг боловсруулахдаа хаягдлын хатуу агууламжийг 64%-тай байлгахгаар төлөвлөсөндөө хүргээгүй, нийцлийг хангаж чадаагүйгээс хаягдлын даланд их хэмжээний ус тогтон цуглаж, байгууламжаас гадагш нэвчих эрсдлийг ихэсгэсэн. Хоёрдугаарт, ХД1-ийн сууринд тусгаарлах хана, мөн далангийн байгалийн шаварт бүрхүүлийн цууралт, ан цаваар хаягдал нэвчихээс сэргийлсэн хамгаалалтын зохих давхаргуудын алийг ч хийгээгүй. Гуравдугаарт, ОТ нь ХД1-н периметр тойрогт шүүрэлтийг тогтоон барьж, уурхайгаас доош, Дугат Халив голын гольдрол руу урсаж орохоос сэргийлэн тусгаарлах хана, шуудууг зүй ёсоор нь барьж байгуулаагүй байна.

Гурван жилийн дараа буюу 2024 онд ОТ нь ХД1-ийн ус нэвчилтийн үндсэн шалтгааныг засч залруулах, нутгийн малчдад үзүүлэх нөлөөллийг арилгах чиглэлээр хүч нөөцөө дайчлан ажиллахгүй байсаар байна. Оюу Толгой ХД дахь хатуу агууламжийг 64 хувьд хүргээгүй хэвээр бөгөөд шүүрэлтийн улмаас уурхайн ойр орчмын бэлчээр, ус,

¹ ББОНЗ-ийн тайлан 2024 оны 5 дугаар сар, ху. 50. https://admin.ot.mn/wp-content/uploads/IESC_Audit_Report_Oyu_Tolgoi_May_2024.pdf

² Оюу Толгой, Дутагдал Арилгах Арга Хэмжээний Төлөвлөгөөний биелэлтийн тайлан, Улирал 1, ху. 1. <https://admin.ot.mn/wp-content/uploads/Progress-Report-Q1-EN.pdf>

хүмүүсийн эрүүл мэнд, биологийн төрөл зүйлд үзүүлж буй сөрөг нөлөөлөлд төдийлөн анхаарал хандуулахгүй, тоомсоргүй хандсан хэвээр байна. Уурхайгаас доош урссан хаягдлын далангийн шүүрэлт усанд ямар бодис илэрсэн, хөрсөнд яаж нөлөөлж буй талаар албан ёсны бүртгэл тэмдэглэлийг ОТ нь өнөөг хүртэл нийтэд дэлгээгүй л байна. Уурхайгаас доош урсаж буй усны эх үүсвэрээс ундаалдаг малчдыг, тэдний мал сүргийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах төлөвлөгөө байгаа эсэхийг ОТ нь мэдээлсэнгүй. Шүүрэлтийн цар хүрээ, урт удаан хугацаанд хүн, малын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн тухай малчид эсвэл ямар ч мэдлэггүй эсвэл маш бага мэдлэг, мэдээлэлтэй байна. ОТ нь ХД1-ээс учруулсан хохирлоо арилгаж дуусаагүй байж шинээр барьж байгуулсан хаягдлын далан 2-ыг (ХД2) ашиглалтад оруулаад байна.

Аккаунтэбилити Коунсел 2024 оны 9 сард томилолтоор ажиллахдаа тухайн үед уурхайд хамгийн ойр амьдарч буй малчин айл өрхүүдээр орж, шүүрэлт, уул уурхайтай холбоотой тулгамдсан асуудлыг МТБ-ийн төлөөлөгчидтэй хэлэлцэж, ОТ-н ХХБ-г газар дээр нь очиж үзсэн болно. Түүнчлэн Баруун-өмнөдийн судалгаа, мэдээллийн төвийн Судалгааны захирал Пол Робинсон ОТ-оос зохион байгуулсан Усны үр ашгийн семинарт оролцлоо. Уг томилолтын үеэр бидний олж илрүүлсэн зүйлс:

- Малчдын бэлчээр багасаж, ус хомсдохын хэрээр амьжиргаагаа залгуулах боломж хумигдаж буй дээр өнгөрсөн жилийн өвөлжилт хүндэрч, малыг цэвэр усаар хангахад ОТ-оос хангалттай дэмжлэг үзүүлээгүй нь ихээхэн хүндрэл учрууж байгаа тухай малчид бидэнд ярилаа.

- ОТ нь 2017 оноос хойш Нийцлийн зөвлөх омбудсманы дэмжсэн үйл явцын үр дүнд тохирон үзэглэсэн Малчдын гомдлыг барагдуулах гэрээнүүдийг (МГБГ) бүрэн хэрэгжүүлэх чиглэлээр хангалттай ахиц дэвшил гаргаагүй байна. Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих томоохон төслүүдийн ихэнх нь үр дүнд хүрээгүй хэвээр байгаа нь уурхайгаас шалтгаалан үүссэн нийгмийн томоохон асуудлуудыг тоомсорлохгүй орхигдуулж байна.

- ХХБ-ийн удирдлага үр ашиггүй байгаагаас малчид ашиглаж болохуйц усаа өдөр бүр хэдэн тонноор нь алдаж байна. Малаа услах ус олохын төлөө үйлээ үзэж буй малчдыг дэмжихийн оронд ХХБ-д их хэмжээний усыг хуримтлуулан түгжиж байна.

- Бидний уулзсан бүх малчин айл өрхөд зохих мэдээлэл өгөөгүй, ус нэвчилтийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ОТ нь малчидтай зөвлөлдөөгүй байсан. Малчид шууралт гарч гэнэ гэсэн ам дамжсан яриа сонссон уу гэхээс, өөрсдийнх нь эрүүл мэнд, мал амьтан, хөрс, ус, хүрээлэн буй орчин, биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийн талаар, мөн уг нөлөөллийг бууруулах талаар ОТ ямар арга хэмжээ авч байгаа тухайд огт ойлголтгүй байв.

- Оюу Толгой компаниас 2023 оны 12 сард гаргасан Дутагдал Арилгах Арга Хэмжээний Төлөвлөгөөний (ДААХТ) тухай малчид дуулаагүй, төлөвлөгөөг боловсруулахад ч, хэрэгжүүлэхэд ч малчдыг оролцуулаагүй байна. Энэ нь Оюу Толгойн нөлөөлөлд өртсөн иргэдтэй хамтран ажиллах, иргэдийг хамруулах үйл ажиллагаа нь үр дүн муутай, хангалтгүй байгааг илтгэнэ.
- Оюу Толгой уурхайн лицензит талбай доторх бэлчээр ашиглалтыг дээд зэргээр нэмэгдүүлэх замаар бэлчээрийг аврах боломж байгаа хэдий ч цаашид уурхайг өргөтгөх төлөвлөгөөний дагуу хаягдлын далангийн зориулалтаар Оюу Толгой улам их бэлчээрийн газар авах болно. Энэ төлөвлөгөөг малчидтай хэлэлцээгүй бөгөөд малчдыг улам л ус, бэлчээргүй болгохоор байна.

Агуулга

| | |
|---|----|
| 1. МГБГ-ийн хэрэгжилтийг хойшлуулах тусам малчдын амьжиргаанд хүндрэл учирсаар байх болно | 4 |
| 2.ОТ нь ХХБ-ийг олон улсын стандартад нийцүүлж чадаагүй..... | 5 |
| 3. Талуудтай зөвлөлдөх үйл явцыг ОТ нь хангалттай хэмжээнд, утга учиртайгаар хийдэггүй, хаягдлын далангийн шүүрлийн тухай мэдээллийг ил тод байлгасангүй..... | 14 |
| 4. Малчдын амьжиргаагаа залгуулдаг бэлчээр, усны нөөцийг хамгаалах боломж ОТ-д бий..... | 16 |
| 5. Зөвлөмжүүд | 20 |

1. МГБГ-ийн хэрэгжилтийг хойшлуулах тусам малчдын амьжиргаанд хүндрэл учирсаар байх болно

2012, 2013 онуудад малчдаас [Нийцлийн зөвлөх омбудсман](#)д гаргасан гомдлын мөрөөр 2017 онд байгуулсан Малчдын гомдол барагдуулах [хоёр](#) гэрээг (МГБГ) хэрэгжүүлэх үүргийг ОТ хүлээсэн. МГБГ-г бүрэн хэрэгжүүлэхгүй хойшлуулсаар ихэнх амлалт үүргийг анх гэрээнд заасан хугацаанд биелүүлж чадсангүй. Нийцлийн зөвлөх омбудсманы албан ёсны мониторинг 2019 онд төгсгөвөр болсноос хойш ажлын явц удааширсаар байна.

Амьжиргаагаа үргэлжлүүлэхэд хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байгаа талаар малчид түгшүүр, зовнилтой байна. Эдгээр хүндрэлүүдийн ихэнх нь ОТ уурхайн нөлөөллөөс үүдэлтэй хийгээд МГБГ-ийг хэрэгжүүлснээр эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийг зорьж байж. МГБГ-д ОТ нь нөлөөлөлд өртсөн малчдыг усны эх үүсвэрээр хангах, хуучин худгуудыг засварлах, сэргээх, малчин иргэдийн усны хэрэгцээг үргэлжлүүлэн хянах үүрэг хүлээсэн³. Гурван талт зөвлөлийн (ГТЗ) 2023 оны тайланд 2019-2023⁴ онд 80 гар худгийг сэргээн засварлаж, 20 [инженерчилсэн гүний](#) худаг гаргасан хэмээн дурдсан байна. Гэсэн хэдий ч бидний очсон малчин өрхүүдийн ихэнх нь малаа услах усны хүртээмж муу байгаа тухай ярьсан. Бидний зочилсон малчин өрхүүдийн нэг болох 400 орчим малтай айлд ОТ 2011 онд худаг гаргаж өгсөнөөс хойш тус дэм үзүүлээгүй гэж тэд яриу. Одоо тэр худаг нь усгүй, ОТ үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлээгүй учир малаа харангадуулж алдахгүйн тулд өөрсдөө худаг гаргасан аж. Малчдын худгийг сэргээн засварлаж, барьж байгуулсан ГТЗ-ийн хүчин чармайлтыг бид үнэлж байгаа ч худаг нь ажиллахгүй байгаа малчин өрхүүдээс гомдол гарсаар байна. Ашиглалтад орсон худгуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, худаг барих, засаж сэлбэх замаар дэмжлэг шаардлагатай малчин өрхүүдийг нарийвчлан тогтоох ажлуудыг ГТЗ тасралтгүй хийх шаардлагатай байна.

Уурхай нь [олон жилийн турш өргөжин тэлсээр](#) байгаа учир малаа хариулах бэлчээр газар хомс болж байгаа [сорилттой малчид тулгарч байна](#). Олон малчин айл бэлчээрээ хувааж эзэмших шаардлагатай болсон ба энэ нь зөрчилдөөн үүсгэсээр байгаа аж. Бэлчээр хумигдаж, ус хомс болсоор байгаа нь малчдын амьжиргаа муудаж, амьжиргаагаа залгуулах боломж бололцоо өмнөх үетэй харьцуулахад багассан гэсэн үг. Нэг малчин өрхөөс ОТ-н “Амьжиргааг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд төсөл хэрэгжүүлэх санал хүргүүлсэн боловч төслийг нь хэт өндөр өртөгтэй байна гэж үзээд татгалзсан хариу өгчээ. Мөн малчдын амьжиргааг дэмжих зорилготой малчдын зах, мал нядалгааны газар байгуулах зэрэг ОТ-с [хэрэгжүүлэхээр амласан](#) төслүүдийн хэрэгжилт хойшилсоор байна⁵. Тогтвортой амьжиргааг дэмжих томоохон төслүүд нь [багассан бэлчээр, хомсдсон усны](#) асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болж, мал аж ахуйг илүү үр ашигтай болгож, цөөн малаас тогтвортой орлого олох боломжийг малчдад олгох зорилготой байсан. Энэхүү стратеги нь бэлчээр талхлалтын асуудлыг шийдвэрлэх тустай байсан ч эдгээр төслүүд хэрэгжээгүй байна⁶. Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэхийн

³ Аккаунтэбилити Коунсел, Бичиг цааснаас ахиц дэвшил рүү, Амлалт 3, 12, 13, 17, <https://tpcprogress.com/commitments/>.

⁴ ГТЗ-ийн жилийн тайлан, ху. 14, <https://www.facebook.com/TripartiteCouncil>. 2024 оны 4 дүгээр сарын 24-нд энд хэвлэгдсэн].

⁵ Аккаунтэбилити Коунсел, Бичиг цааснаас ахиц дэвшил рүү, Амлалт 38, 42, <https://tpcprogress.com/commitments/>.

⁶ ГТЗ-ийн 2023 оны жилийн тайланд мал нядалгааны газар, малчдын зах төслүүдийн ахиц дэвшлийн тухай дурдаагүй байна. ГТЗ-ийн 2023 оны жилийн тайлан, 2024 оны 4 дүгээр сарын 24-нд хэвлэгдсэн <https://www.facebook.com/TripartiteCouncil>.

тулд ОТ шууд хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Бэлчээр, усны хүрэлцээний асуудал Оюу Толгойн уурхайн бүсээс алслагдсан газар аж төрж буй малчдад ч нөлөөлнө, учир нь уурхайн ойролцоо амьдардаг малчид амьжиргаагаа залгуулахын тулд бусдын бэлчээр нутаг руу нүүхээс өөр аргагүйд хүрэх ба энэ нь домино үр дагаварыг үүсгэнэ.

ГТЗ нь МГБГ-ийг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлж байгаа ч⁷ эдгээр амлалтыг шинэчилж, цаг тухайд нь гэрээнүүдийг бүрэн бүтэн хэрэгжүүлэхийн тулд илүү их хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай байна. **ГТЗ нь МГБГ-ийн хэрэгжилтийг нарийн хянах арга хэрэгсэлтэй болох, хэрэгжилтийг удаашрахаас сэргийлэхийн тулд хэрэгжилтийн цаг хугацааг шинээр гарган боловсруулах ёстой. Мөн ОТ нь эдгээр амлалтуудыг цаг тухайд нь, үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эдгээрийн хэрэгжилтийг тэргүүн чиглэлээ болгон, хэрэгжүүлэх ажлыг түргэсгэх ёстой.**

2. ОТ нь ХХБ-ийг олон улсын стандартад нийцүүлж чадаагүй

Зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, үйл ажиллагааны янз бүрийн асуудлаас шалтгаалан ХХБ нь одоогоор хаягдлын менежментийн **хамгийн сайн туршлагыг нэвтрүүлж** ажиллахгүй байна. ХХБ-ийн удирдлагын баг эдгээр дутагдлуудын талаар мэдэж байгаа ба асуудлуудыг засч залруулахын тулд **үр дүнтэй шийдлүүдэд хөрөнгө оруулалт хийж, тэдгээрийг цаг алдалгүй нэвтрүүлэх** нь ОТ-н удирдлагын багаас шалтгаалах юм. Хаягдлын менежментийн тогтолцоог бэхжүүлэх арга замын талаар нээлттэйгээр санал солилцож буй ОТ-н удирдлагын багийнханд талархахын зэрэгцээ малчдын санааг зовоож буй гол асуудал болох нэвчилт, шүүрэлтийг үүсгэж буй үндсэн шалтгааныг арилгах, урьдчилан сэргийлэх; байгаль орчин, орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалах олон улсын стандартыг хүндэтгэхийг анхаарч хэрэгжүүлэхийг уриалж байна. Малчид, зөвлөхүүдийн гаргасан тэргүүлэх чиглэлүүдээс дэлгэрэнгүйгээр илтгэе.

Уурхай ажиллаж эхэлснээс хойш ОТ хаягдлыг хангалттай хатааж чадаагүйгээс нойтон хаягдал ХД-ийн дотор хананы гэмтсэн хэсгээр амархан нэвчиж байна. ОТ-н төлөвлөгөөнд хаягдал дахь хатуу агууламжийг 64%-д хүргэх боломжтойг харуулсан бөгөөд 2012 оны БОННУ-нд “Эцсийн баяжмалыг 65% хатуу бодис хүртэл өтгөрүүлнэ” гэж заасан⁸. Энэ загварыг баталсан. Энэ нь зөвхөн хүрч болохуйц үзүүлэлт төдий биш, зөвшөөрлийг өгөхдөө үндэслэн баримталсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт юм. ОТ нь хаягдлын хатуу агууламжийн хувийг 56%-с өсгөсөн хэдий ч хатуу агууламжийн хувь хэзээ ч 64% хүрч байсангүй. Бид энэ асуудлыг ОТ багийнханд хөндөн тавихад, ОТ сайжирсан, одоогийн хаягдал дахь хатуу бодисын дундаж агууламж (**2024 оны байдлаар хатуу агууламж 59.8%**) зохистой түвшинд байгаа гэж хариулав. ОТ энэ чиглэлээр үйл ажиллагаагаа сайжруулсан нь сайшаалтай хэдий ч одоогийн гүйцэтгэлийн түвшинг хүлээн зөвшөөрөх аргагүй юм. Учир нь 60% ба 64%-н хатуу бодисын агууламжийн хооронд гарах ялгаа нь их буюу илүүдэл усны нэг хувь тутамд нэг сая орчим литр ус ногддог учир хаягдлын лагийн шинж чанарыг өөрчлөхөд хангалттай бөгөөд шүүрлийг багасгахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх болно.

Хаягдал нойтон байх тусам нэвчилтийн хурдад шууд нөлөөлөөд зогсохгүй, ус хомс цөлийн экосистемд усыг дахин боловсруулах боломжийг ОТ алдсаар байгааг харуулж байна. Хэдэн жилийн турш хаягдал дахь усыг багасгаж чадаагүйгээс болж дахин

⁷ ГТЗ-ийн 2023 оны жилийн тайланд, ху. 13, МГБГ-н 64 амлалтаас 26-г нь биелүүлсэн гэжээ. ГТЗ-ийн 2023 оны жилийн тайланг эндээс <https://www.facebook.com/TripartiteCouncil>, 2024 оны 4 дүгээр сарын 24 хэвлэгдсэн.

⁸ 2012 ОТ БОННУ А4, ху.31/77.

боловсруулж болох байсан сая, сая литр ус үрэгдэж, долларыг сая, саяар нь алдаж байна. 2013-2017 онуудад ОТ-н хаягдал дахь хатуу бодисын хэмжээ 56% (буюу зураг төслийн төлөвлөсөн стандартаас 8%-иар доогуур)⁹ байснаар жил бүр 1.46 сая долларын усыг дэмий үрсэн байна. 2018-2024 онуудад ОТ хаягдал дахь хатуу бодисын хэмжээг дунджаар 60%-д хүргэснээр (стандартаас 4%-иар доогуур) уул уурхайд орлуулсан ашиглах усанд жил бүр 730,000 доллар зарцуулдаг гэсэн үг¹⁰. 2017 оноос хойш ОТ компани нь 248.2 сая литр ус алдсанаас болж ойролцоогоор 12.41 сая долларыг дэмий үрсэн байна¹¹.

ОТ нь усыг дахин боловсруулах түвшинг салбарын стандартын дагуу сайн байгаа гэдэг ч, орон нутгийн малчдад усны нөөц амин чухал байдаг хуурай орчинд үйл ажиллагаагаа явуулж буй энэ уурхай ус боловсруулалтыг илүү сайн хийж чадах чадвартай, тэгэх ч ёстой гэж бид үзэж байна.

Цаашлаад хаягдал дахь хатуу бодисын агууламж 60% байна уу, 65% уу гэдгийн хооронд мэдэгдэхүйц ялгаа буйг сайн судлан тогтоосон байдаг. "Чили, Перу улс дахь өтгөрүүлсэн хаягдлын тогтвортой менежмент"-ийн судалгаанаас үзэхэд хаягдал дахь хатуу бодисын агууламж 65%-д хүрэхэд хаягдалд ус ялгардаггүй хийгээд хаягдал өтгөрүүлэгч технологи буюу "өндөр нягтралтай өтгөрүүлэгч" НДТ-г ашигласнаар хаягдал дахь хатуу бодисын хувийг энэ тоонд хүргэж болдог агаад яг энэ технологийг ОТ ашиглаж байгаа¹². Ийнхүү хаягдлын хатуу агууламжийг "хаягдлын шингэнгүй" түвшинд хүргэвэл хаягдлаас ямар ч шингэн шүүрэхгүй гэсэн үг юм. Иймд ХД1-ийн шүүрлийг хэдэн арван жилээр үргэлжлэн нэвчихийг зогсоохын тулд хаягдал дахь хатуу бодисын агууламжийг 64%-65% хувьд хүргэх нь маш чухал юм.

Рио Тинто нь хаягдлынхаа хатуу агууламжийг дор хаяж 64% байлгах нөөцтэй¹³. Хаягдлыг боловсруулах ажиллагааны гол хэсэг нь хаягдлыг том саванд хутган өтгөрүүлэх үйл явц юм. Үүний дараа хаягдлыг далан руу шилжүүлдэг. ОТ одоогоор хоёр өтгөрүүлэгчтэй бөгөөд хоёуланд нь аль 2014 онд эвдрэл гарсан байх магадлалтай тул 100%-н хүчийн чадлаараа ажиллаж чадахгүй байгааг Усны үр ашгийн семинарын үеэр зөвлөхүүд биечлэн харсан билээ¹⁴. Эвдрэлтэй хоёр өтгөрүүлэгчийг засах, хаягдал дахь

⁹ Олон талт баг, Хараат бус шинжээчдийн багийн хамтарсан баримт судалгааны тайлан, 2017 оны 1-р сар, ху. 207. 2024 оны 7-р сарын 9-ний өдрийн ХХБ-ын Дутагдал Арилгах Арга Хэмжээний төлөвлөгөөний талаарх Аккаунтэбилити Коунселын тайлбарт өгсөн ОТ-н хариу, хавсралт 1.

¹⁰ 2024 оны 9-р сарын ОТ-н Усны үр ашгийн семинарын үеэр хийсэн хэлэлцүүлэгт үндэслэн тооцоолсон. 0.51 ам. доллар нь Гүний хоолойн үст давхаргын нэг шоо метр усны зардлын ойролцоогоор хийсэн тооцоолол юм. 0.50 ам.доллараар тооцвол 1 тонн ус = 1000 литр = 1 шоо метр = 0.50 ам.доллар болно. 1000 тн/хоног = Гүний хоолойноос орлуулах өдөрт 500.00 ам.доллар = хаягдлын 1%-ийн илүүдэл ус. Жилд 1,000 x 365 хоног x 0,50 = 182,000 ам.доллар гэдэг нь зураг төслийн зорилтоос буюу 64%-с доогуур хувь тус бүрд хаягдал руу хаягдсан усыг нөхөх зардал юм.

¹¹ Таамаглал тооцоо: 2013–2017 онуудад (5 жилийн турш хаягдал дахь хатуу бодис 56%) = жилд 1.46 сая доллар x 5; 2018–2024 (7 жилийн турш хаягдал дахь хатуу бодис 60%) = жил бүр 730,000\$ x 7.

¹² Карлос Каччуттоло Варгас, Алекс Маринович Пулидо, Чили, Перу дахь өтгөрүүлсэн хаягдлын тогтвортой менежмент: практик туршлага ба нийгэм, байгаль орчны хүлээн зөвшөөрөгдөх байдал, 2022 оны 8-р сарын 31, зураг 1. <https://www.mdpi.com/2071-1050/14/17/10901>

¹³ ОТ-той төстэй, дийлэнх хувийг нь Рио Тинто эзэмшдэг Аризона дахь Рэзолиушн Майн зэсийн уурхай нь хатуу бодисын агууламжийг 65%-д хүргэхээр төлөвлөж байна. Рэзолиушн зэсийн уурхай. Үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, 2016 оны 5-р сарын 9, ху. 137, <https://www.resolutionmineeis.us/sites/default/files/project-files/resolution-copper-gro-vol-1-20160509.pdf>

¹⁴ "Өнгөрсөн жил үйлдвэрлэлээ эхлүүлж байсан тул эхний улиралд ашиглалтад орсны дараах асуудал, тэр дундаа хаягдал өтгөрүүлэгчийн тармуурын ирний эвдрэл зэрэг нь үйлдвэрлэлийн нэг шугамыг долоон 7 хоногийн турш зогсоосон зэрэг нь энэ маш том уурхайн олборлолтод ихээхэн нөлөөлсөн." Хенри Лазенби, "Оюу толгойн баяжмалын өтгөрүүлэгчийн тармуур дахин эвдэрсэн" Инженерийн мэдээ, 2014 оны 9-р сарын 10 (<https://www.engineeringnews.co.za/article/oyu-tolgoi-concentrate-thickener-rake->

хатуу бодисын агууламжийг сайжруулах урт хугацааны стратегийн нэг хэсэг нь гурав дахь өтгөрүүлэгчийг авч суурилуулах шаардлагатай гэдгийг ОТ мэдсээр ирсэн. Гурав дахь өтгөрүүлэгчийн худалдан авалтыг хойшлуулах тусам, ОТ нь хаягдлын далангийн шүүрлээс болж байгаль орчин, эрүүл мэндэд учрах нөлөөллийг арилгахыг бус, өөрийн ашиг орлогоо тэргүүн ээлжинд тавьсаар байгаа гэдгийг л илтгэнэ. Учир нь хаягдлын хатуу агууламжийг 64%-д хүргэхээс нааш хаягдлын далангаас нэвчилт, шүүрэлт гарсаар байх нь ойлгомжтой.

ОТ өөрийн зураг төсөлд заасны дагуу хаягдлаа хатаагаагүйгээс шүүрэлт үүсч, байгаль орчин, нутгийн малчид, олон нийтэд (хохиролын хэмжээг одоогоор тооцоолоогүй байгаа ч) бодитой хохирол учруулсан¹⁵. Хэдийгээр ОТ хаягдал дахь хатуу агууламжийг 64%-д хүргэж чадаагүйгээ хүлээн зөвшөөрч, уурхайн орчмын иргэдэд шүүрлийг хяналтад авсан гэж мэдэгдсэн ч компани нь одоогоор хаягдал дахь хатуу бодисын агууламжийн асуудлыг шийдвэрлэх гурав дахь өтгөрүүлэгчийг ч суурилуулаагүй, ямар нэгэн өөр алхам ч хийгээгүй л байна. Өөрөөр хэлбэл, шүүрэлт үүсэх үндсэн шалтгаануудын нэгийг засч шийдвэрлээгүй хэвээр байгаа энэ нөхцөлд ирээдүйд шүүрэлт гарах нь баараггүй. ОТ нь шүүрэлт үүсэх эрсдлийг үр дүнтэй бууруулахын тулд хаягдал дахь хатуу агууламжийн хэмжээг аль болох өндөр хувьд хүргэх ёстой.

ХД1-ийг барих үед доторлогоо, тусгаарлах ханыг хийхдээ доголдол гаргасны улмаас үл нэвчих зузаан шавран доторлогоот давхарга байх байсан газраар хэт шингэн хаягдал шүүрсэн.

Хаягдлын далангаас тодорхой хэмжээний шүүрэлт, нэвчилт гарахыг ОТ хэвийн үзэгдэл гэх болов ч, уурхайн талбайн гаднах хөрс болон гүний усыг хаягдлын шүүрэлт, нэвчилтээр бохирдуулахгүйн тулд ус үл нэвтрэх доторлогоо, зохистой тусгаарлах ханыг суурилуулан шүүрлийн эрсдлийг аль болох багасгаж, нэвчилтийг бууруулах арга хэмжээг авч ажиллах нь ОТ-н үүрэг юм. Гэвч эрсдэл бууруулах эдгээр аргуудын алийг нь ч ХД1 дээр авч хэрэгжүүлээгүй байна.

Хаягдлын далангийн суурийг тэр чигээр нь сайтар доторлох нь болзошгүй шүүрэлтээс хамгаална¹⁶. Доторлогоо хийх нь энэ үйлдвэрлэлийн стандарт практик юм¹⁷.

[arms-fail-again-2014-09-10](#)). Санхүүгийн хязгаарлалтуудаас шалтгаалан гурав дахь хаягдал өтгөрүүлэгчийг нэмэх хүсэлгүй байгаагаа ОТ мэдэгдэв.

¹⁵ "ХХБ-ийн шүүрэлтийн орчны мэдрэмтгий хүлээн авагч нь гүехэн аллювийн хөрсөнд агуулагдах гүний ус юм. Үүнд Дугат Халив голын түр сувгууд ч орно. Усны эдгээр сувгуудаас малчид ч, зэрлэг ан амьтад ч ундаалж байгаа. Иймд ХХБ-ийн аливаа шүүрэлтийн судалгааг гидрогеологийн эдгээр нэгжүүд дээр хийх ёстой. ХХБ-ийн шүүрэлт нь Дугат Халив голын түр сувгийн аллювийн хөрс рүү шилжсэн нь усан дахь хүнд металлын агууламж (НУХБХ-ийн концентраци) ихэссэнээр нотлогдож байгаа бөгөөд шүүрэлтийг тогтоон барих бүх хаалтыг даван туулж нэвчиж байна. Энэхүү шүүрэлт нь уурхайн лицензит газрын гаднах гүехэн хөрсөнд илэрсэн болоод хүнд металлын ихэссэн агууламжтай бохирдол нь орчны хөрс, усанд хэр хол, ямар цар хүрээнд шингэснийг тогтоогоогүй байна. ОТМБ 16-86 (уурхайгаас ойролцоогоор 1км доош) байршилд болон Байшинтын малчны худаг дээр (уурхайн талбайгаас доош 7 км зайнд) хаягдлын шүүрэлтээс гүний усанд нэвчилт үүссэн шинж тэмдэг илрээгүй байна." ББОНЗ 2024 оны 5-р сарын тайлан, ху. 62.

¹⁶ 2012 ANCOLD Хаягдлын далангийн удирдамж, ху. 41, <https://www.resolutionmineeis.us/sites/default/files/references/ancold-2012.pdf>.

¹⁷ "Хаягдлын химийн шинж чанар болон хүрээлэн буй орчноос хамааран инженерийн хийцтэй ХХБ нь хөрс, усны тогтолцоонд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлэхийн тулд ихэвчлэн нэвчилт багатай хөрсний давхаргаас бүрдэх доторлогооны систем дээр өндөр нягтралтай полиэтилен (HDPE) зэрэг геосинтетик доторлогоог нэмж бүрдүүлсэн нийлмэл доторлогоотой байдаг". Ньюмонт, Хаягдлын мэдээллийн хуудас, 2020 оны 8-р сар,

Хаягдлын цөөрмийг төрөл бүрийн байгалийн болон синтетик материалуудаар доторлох нь үр дүнтэй байдаг ч салбарын хороо ANCOLD-с дараах сануулгыг өгсөн байна: “Байгалийн шаварт ан цав, нүх сүв гардаг учир харьцангуй өндөр нэвчилттэй байдаг тул дахин боловсруулах, нягтруулах шаардлага гардаг”¹⁸ гэжээ. Бидний ОТ-д илгээсэн олон тооны хүсэлтийг үл харгалзан, ОТ нь ХД1-ийн доторлогоог зөв зохистой хийсэн гэдгийг нотлох тайлан эсвэл “аз-билт” барилгын гүйцэтгэлийн зургийг бидэнтэй хуваалцсангүй.

Байгаль орчин, нийгмийн бие даасан зөвлөхүүдийн (IESC) 2022 оны тайланд “ХХБ-ийн нэг дүгээр далангийн суурийн хойд болон баруун талын дийлэнх хэсэг нь байгалийн зузаан шавартай, харин 1-р далангийн байгалийн шавар бага эсвэл огт байхгүй зүүн өмнөд буланд 1 метр зузаан нягтруулсан шавар доторлогоог хийсэн *бололтой*”¹⁹ гэжээ. ОТ нь байгалийн болон инженерчлэн нягтруулсан шаврын тухайд ямар нэгэн баримт мэдээлэл өгөөгүй, бөгөөд инженерийн шугаман доторлогоо барьсан гэх хэсэгт шүүрэл үүссэнийг харгалзан үзвэл, хийсэн гэх доторлогоо нь жигд байгаагүйгээс нэвчилт үүссэн байх магадлалтай²⁰.

Доторлогоог зохих ёсоор хийгээгүй дээр тусгаарлах хана гаргаагүй нь мөн л шүүрэл нэвчилтээс сэргийлэх ажлыг дутуу хийснийг илэрхийлнэ²¹. ОТ-н ХХБ-ийн адил хаягдлын далан нь аллювийн хөрс, тунадасны давхарга дээр суурилж байгаа тохиолдолд тусгаарлах хана нь маш чухал үүрэг гүйцэтгэдэг²².

ХХБ-ийн 2011 оны анхны зураг төсөлд геологийн өгөршөөгүй ул чулуулгийн давхаргад тулсан тусгаарлах ханыг хаягдлын даланд барихаар тусгасан²³. Үүнийг хийж чадаагүйг уурхайн талбайнаас гадагшилсан шүүрэлт нотолж байна. Бид ХД1-г анхны зураг төслийн дагуу барьсныг батлах зорилгоор барилгын гүйцэтгэлийн зургаг, тайланг авах хүсэлт гаргасан боловч эдгээр аз-билт баримт бичигтэй танилцах боломжийг бидэнд олгосонгүй.

Эдгээр алдаа дутагдал нь зөвхөн ХД1-ээр хязгаарлагдахгүй гэдэгт бид санаа зовж байна. ХД1-ээс хаягдал ус шүүрч буй нь тухайн далангийн үйл ажиллагааны мөчлөгийн төгсгөлд буюу ОТ нь 2033 он хүртэл ашиглагдах дараагийн далан болох ХД2-ыг баригдаж байх үед олон нийтэд мэдэгджээ. ХД2 нь суурь доторлогоо, далангийн хамтаар баригдан 2023 оны дунд үеэс²⁴ эхлэн ашиглалтад орсон ба малчид болон

https://s24.q4cdn.com/382246808/files/doc_downloads/sustainability/environmental/Tailings-Fact-Sheet.pdf.

¹⁸ Id. 41-д.

¹⁹ ББОНЗ тайлан, 2022 оны 9-р сар, ху. 42 (онцолсон тэмдэглэгээг нэмэв)

<https://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/202209-iesc-monitoring-report-oyu-tolgoi-mine.pdf>.

²⁰ Id.

²¹ “Суурийн нэвчилтийг хязгаарлах, зохицуулах аргад тусгаарлах хана, суваг шуудуу эсвэл худаг, чигжээс, шүүрэлт үүсэх цэгийн доорхи цөөрөм/далан зэрэг орно. Нэвчилт үүсэх магадлалатай суурин хэсгүүдэд тусгаарлалтын хана барих нь нэмэртэй.” 2012 ANCOLD Хаягдлын далан барих удирдамж, х. 41.

²² “Суурь элс, хайрга, шороо, хөрс гэх мэт нэвчилттэй давхаргатай бол шүүрэлтийг хянах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай (5.8-р хэсгийг үзнэ үү). Тусгаарлах хана эсвэл нэвчилтэт хэсгийн доор байрлах шүүрэл чулуулах цөөрөм, далангийн сиситемыг хаягдлын далангийн төрөл, хаягдлын усны шинж чанар, газрын гадаргын байдал, газрын доорх усны горим зэргээс шалтгаалан суурилуулах шаардлагатай байж болно.” Id. 53-д.

²³ Тусгаарлалтын хана нь ан цав, нүх сүвгүй (өгөршөөгүй) ул чулуулгийн давхаргад тулсан байх ёстой. Тэгээгүй тохиолдолд чулуулгийн ан цаваар хаягдлын шингэн нэвтчин хаягдлын далангийн гадуурх хөрс, гүний усанд шингэх боломжтой.

²⁴ Аккаунтэбилити Коунсел нь 2023 оны 8-р сараас хиймэл дагуулын зургаар дамжуулан ХД2-ын үйл ажиллагааг ажиглаж байгаа болоод хаягдлын далан руу шингэн юүлэгдэж буйг үг дүрсүүд дээрээс харж болно.

зөвлөхүүдэд доторлогоо, мөн тусгаарлах хана нь ул чулуулганд хүрч хийгдсэн эсэхийг ажиглах боломжийг олгосонгүй. ХД1-аас шүүрэл үүссэн учраас ОТ нь ХД2-оос шүүрэл, нэвчилт гарахаас урьдчилан сэргийлэхийн тулд хаягдлын далангийн зураг төсөлд томоохон өөрчлөлтүүдийг хийсэн гэдгээ олон нийтэд мэдэгдэв²⁵. ОТ-н зүгээс ХД2-ын нийт суурь талбайн дагуух доторлогоог зохих ёсоор хийсэн ба тусгаарлах ханыг өгөршөөгүй ул чулуулагтай барьцалдуулан дүүргэж, ус үл нэвтрэх шаварлаг давхарга дээр даланг барьсан гэж мэдэгдсэн хэдий ч ХД2 ашиглалтад орохын өмнөхөн нэгэн малчны авч бидэнтэй хуваалцсан гэрэл зурган дээр ХД2-оос ургамал ургаж байгаа нь харагдаж байгаа ба зохих доторлогоо хийсэн бол далан баригдсан газар дээр ургамал байх боломжгүй юм.

²⁵ “ХХБ-ийн 1-р далангийн нэвчилтийг хүлээн зөвшөөрч, ОТ нь ХХБ-ийн 2-р далангийн зураг төсөлд томоохон өөрчлөлтүүдийг хийсэн бөгөөд үүнд (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй): ХХБ-ийн 2-р далангийн хананы доор шүүрэлтийг цуглуулах системийг сууриллуулах; инженерийн гүн шугам бүхий тусгаарлах ханыг ХХБ-ийн 2-р далангийн периметрээр бүхэлд нь сууриллуулах. Энэ тусгаарлах хана нь багадаа 4 метр, зарим ан цав, нүх сүв гарсан элс, шавартай газраа 12 метр гүн байна”. Усны нарийвчилсан үнэлгээний тайлан, ху. 12-р, 2023 оны 9-р сар https://admin.ot.mn/wp-content/uploads/Detailed_Water_Review_Report__OT_September_2023_-_EN.pdf.



2023 оны 7-р сард буюу ХД2 ашиглалтад ороход бэлэн болсон үед нэгэн малчны авсан энэхүү гэрэл зурган дээр ХД2-ын суурин дээр ургамал, бут ургаж байгаа нь харагдаж байна. Энэ зургийг АК-ын зөвшөөрөлтэйгээр оруулав.

ХД2 нь зураг төслийн дагуу баригдсан болохыг баталгаажуулахын тулд барилгын гүйцэтгэлийн зураг төсөл, тайланг харах, мөн тусгаарлах хана өгөршөөгүй ул чулуулагт тулж хүрч байгаа үгүйг нотлохын тулд геологийн газрын зураглалыг харах хүсэлтийг бидний зүгээс тавьсан боловч эдгээр баримт бичгийг бидэнд үзүүлсэнгүй. Өнгөрсөн хугацаанд итгэл алдах явдал гарч байсныг харгалзан²⁶ эдгээр баримт бичгүүдийг МТБ, малчид, тэдний зөвлөхүүдтэй ил тод байдлаар хуваалцах нь ОТ-н зүгээс гаргаж буй мэдэгдлүүдийг нотлоход шаардлагатай юм.

²⁶ Итгэл алдагдсаны нэг жишээ бол орон нутгийн малчдад нэвчилт гарсан тухай мэдээлэхгүй удсан явдал юм. Дэлгэрэнгүйг 3-р хэсгийн 1-р догол мөрнөөс харна уу.

Зээлдүүлэгчид ОТ-д хариуцлага тооцож, холбогдох стандартуудад нийцэж ажиллахыг шаардах нь

Зээлдүүлэгчид ОТ-н зураг төсөл, үйл ажиллагаанд зохих хяналтыг тавьж чадаагүй нь өнөөдөр малчдад учирч буй сөрөг нөлөөллийг буй болгосон. ОТ-н 2011 оны ХД1-н анхны зураг төслийг хүлээн зөвшөөрөөгүй, буцаасны нэг шалтгаан нь шаардлагад нийцээгүй доторлогоотой холбоотой байсан ба²⁷, хожим гаргасан зураг төслийг баталсан ч батлах үйл явц ил тод байсангүй. Өөрчлөлт оруулсан загваруудыг нийтэд нээлттэй болгоогүйгээс зураг төслийн шийдэл, тэдгээрийн нөлөөллийн талаар бодитоор зөвлөлдөх боломжийг малчид болон зөвлөхүүдэд олгоогүй. Энэ ч утгаараа зээлдүүлэгчид анхны зураг төслийн буцаагдсан шалтгаануудыг судлах, зураг төслийг засварлуулан хянах ажлаа хийгээгүйгээс хэдэн жилийн дараа далангаас шүүрэл гаргахад хүргэсэн байна.

ОТ өөрийн ХХБ-ийн ажиллагааг сайжруулах бүрэн боломжтой. ОТ нь шаардлагатай шийдлүүдэд хөрөнгө оруулалт хийвэл хаягдал дахь хатуу агууламжийг 64% ба түүнээс дээш байлгах боломжтой. Ингэснээр ОТ нь өөрийнхөө гаргасан төсөл зургийн дагуу ажиллаж эхэлнэ гэсэн үг. ОТ ХД2-ын зураг төсөл, гүйцэтгэлийн зургуудыг малчид, малчдын зөвлөхүүдтэй хуваалцсанаар тухайн далан зохих доторлогоотой, далангийн тусгаарлах хана нь өгөршөөгүй ул чулуулгийн давхаргад тулсан гэдгийг батлах боломжтой болно. Шаардагдаж буй эдгээр үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах олон улсын стандартуудад бүрэн нийцнэ.

а) Рио Тинтогийн стандартууд

- Рио Тинто 2012 онд "D5 Хаягдал хадгалах байгууламж ба ус хадгалах байгууламжийн менежмент" удирдамжаа нийтэлсэн бөгөөд үүнийг хамгийн сүүлд 2021 онд шинэчилжээ²⁸. D5 стандарт шаардлагын дагуу ХХБ-ийн зураг төсөлд уурхайн барилгын ажил, ашиглалт, хаалт, хаалтын дараах ажиллагаа зэрэг уурхайг ашиглах нийт хугацааны туршид гарах "эрсдлийн шийдлийг" тусгаж, тэдгээр эрсдлийг бууруулах инженерийн болон ашиглалтын арга хэмжээг тодорхойлсон байх ёстой аж²⁹. Хаягдлын далангаас нэвчилт, шүүрэлт гарч хяналтаас гарсан явдал нь эрсдлээс сэргийлэх, шүүрлийн нөлөөллийн эрсдлийг бууруулахыг ХХБ-ын зураг төсөлд тусгасан байх ёстой гэдгийг сануулсан нэгэн тод жишээ юм³⁰. Энэ стандартын нийцлийг хангахын тулд **ОТ-н 2012 оны БОННУ-нд шүүрэл үүсэх эрсдлийг тодорхойлж, шүүрлээс урьдчилан сэргийлэх,**

²⁷ Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2013 оны 03 дугаар сарын 12-ны өдөр "ОТ ХХК нь "Оюутолгой уурхайгаас алт, зэс олборлох, боловсруулах хамтарсан төсөл"-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд заасан шаардлага, нөхцөлийн дагуу хаягдлын байгууламжийн доторлогоонд өтгөрүүлсэн хаягдлыг нэвчихээс сэргийлэх синтетик материал ашиглаагүйгээр эдгээр шаардлага, нөхцлийг зөрчсөн. Манай газраас тус уурхайд хоёр удаа шалгалт хийж, нөхцөл байдлыг засч залруулах хугацааг ОТ-д тогтоосон бөгөөд өтгөрүүлсэн хаягдлын байгууламжийн загварыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд заасан шаардлага, нөхцөлийн дагуу гаргах хүртэл Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас ХХБ-г ашиглалтад оруулахыг зөвшөөрөх боломжгүй гэсэн албан бичиг өгсөн."

²⁸ Рио Тинто 2021 *Группын журам – D5 – Хаягдал болон ус хадгалах байгууламжийн менежмент v1.2*. <https://www.riotinto.com/-/media/Content/Documents/Sustainability/Corporate-policies/RT-Management-tailings-water-storage-procedure.pdf?rev=de446fc5d65742b4bf6d597a2eb30ae1>.

²⁹ Рио Тинто 2021 *Хаягдлын менежмент ба ус хадгалах журам*, ху. 17.

³⁰ D5 стандарт нь хаягдлын байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа "... улирлын болон эрс тэс цаг агаар, үйл явцын эвдрэлийн нөлөө, нэвчилт... гүний усны урт хугацааны нөлөөлөл, хяналт зэргийг харгалзан үзэхийг" шаарддаг. Id. ху. 5.

шүүрэл гарвал нөлөөллийг бууруулах зохих арга хэмжээг тусгасан байх ёстой атал эдгээрийг тусгаагүй байна. Нэвчилтийг арилгахад чиглэсэн Дутагдал Арилгах Арга Хэмжээний Төлөвлөгөө нь алдаа дутагдал гарсны дараа, хэт хожуу арга хэмжээ авч буй оролдлого юм. Гэвч ДААХТ нь шүүрэлтэийн шинж тэмдгийг арилгахад чиглэгдэн, шүүрэлтийн үндсэн шалтгаан болох хатуу агууламжийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдээгүй байгаа учир хангалттай шийдэл болж чадахгүй байна.

- D5 стандарт нь уул уурхайн операторуудаас олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал, байгаль орчны нөлөөллийг бууруулахад чиглэсэн гүйцэтгэлийн зорилтуудыг тогтоохыг шаарддаг. Зорилтууд биелж байгаа эсэхийг тогтмол үнэлж, сайжруулах шаардлагатай бол залруулга хийж байх ёстой аж³¹. Энэхүү стандартыг дагаж мөрдөхийн тулд ОТ нь малчдад шүүрлийн химийн найрлагын талаар мэдээлэл өгч, эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндэд нь нэвчилтээс үүдэлтэйгээр гарсан аливаа хор уршгийг цаг тухайд нь илрүүлж, арилгах ёстой.

б) Зээлдүүлэгч байгууллагуудын стандартууд

- ЕСБХБ, ОУСК зэрэг зээлдүүлэгчдийн нийгэм, байгаль орчны хамгааллын бодлогод компаниуд байгаль орчныг бохирдуулах, орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд хохирол учруулахаас зайлсхийхийг шаарддаг. Тухайлбал, ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлогод (БОНБ) төсөл хэрэгжүүлэгчид “аюултай бодис, материалтай холбоотой эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах, удирдахыг”³² зааварчилсан, түүнчлэн төсөл хэрэгжүүлэгчдээс “хаягдал материалтай харьцах, боловсруулахтай холбоотойгоор үүсэх ялгаралт, үлдэгдэлд зохих хяналт тавьж, [хог хаягдал]-ыг байгаль орчинд ээлтэй, аюулгүй аргаар, холбогдох тохиолдолд ЕХ-ны байгаль орчны стандартын дагуу холбогдох журмын дагуу зохих ёсоор боловсруулах ба/эсвэл зайлуулахыг шаардсан байдаг.”³³ Хаягдлын далангаас хяналтгүйгээр алдагдаж буй шүүрэлт нь аюултай бодис агуулсан хаягдал материалын хувьд гүний усны эх үүсвэрийг бохирдуулах эрсдэлтэй. **ОТ нь ийм эрсдэл гаргахаас зайлсхийх, эрсдлийг багасгах үүрэгтэй. Үүний зэрэгцээ ЕСБХБ, ОУСК зэрэг зээлдүүлэгч байгууллагууд ОТ компани нь байгаль орчин болон орон нутгийн иргэдэд хохирол учруулахгүйгээр өөрийн хог хаягдлыг зохих ёсоор боловсруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах хариуцлага хүлээх учиртай.**
- ОУСК-ийн Уул уурхайн салбарын Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамжид “байгаль орчинд хаягдаж буй уурхайн хаягдал усны урсгалыг ... хаягдал ус зайлуулах холбогдох удирдамжийн дагуу боловсруулж, цэвэрлэх ёстой” гэж зөвлөдөг. **ХХБ-ийн шүүрэлт нь энэхүү удирдамжийг зөрчсөн гэж бид үзэж байна. ОТ нь шүүрэлтийн химийн найрлагын талаарх мэдээллийг одоо хүртэл өгөөгүй байгаа ч энэ нь малын усны чанарын стандартаас давсан гэдгийг бид мэднэ**³⁴.

³¹ Рио Тинто 2021 Хаягдлын менежмент ба ус хадгалах журам ху.17

<https://cdn-rio.dataweavers.io/-/media/content/documents/sustainability/corporate-policies/rt-management-tailings-water-storage-procedure.pdf?rev=cd25a89d2bf140a69a998aac9b3a9e1>.

³² 2019 ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого, хэсэг 3, пар. 4, <https://www.ebrd.com/environmental-and-social-policy.pdf>

³³ ЕСБХБ-ны БОНБ, хэсэг 3, пар. 11

³⁴ ББОНЗ тайлан 2022 оны 9-р сар, ху. 45

<https://www.accountabilitycounsel.org/wp-content/uploads/202209-iesc-monitoring-report-oyu-tolgoi-mine.pdf>.

в. Хаягдлын менежментийн дэлхийн үйлдвэрлэлийн стандарт (ХМДҮС):

- Эцэст нь, 2020 оны Дэлхийн хог хаягдлын үнэлгээнд үндэслэн гаргасан ХМДҮС-тад орон нутгийн иргэд болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллөөс урьдчилан сэргийлэхийн тулд хаягдлын байгууламжийн эрсдлийг зөв удирдах шаардлагыг уул уурхайн компаниудад тавьсан. ХМДҮС"-ын шаардлагад "Налуугийн тогтвортой байдал, шүүрэлтийн менежментийн аюулгүй байдлын хүчин зүйлүүд гэх мэт зураг төслийн шалгуурыг хэрэглэх, ингэхдээ материалын ашиглалтын шинж чанарын тооцоо, зураг төслийн элементүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэл, эрсдлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн чанар зэргийг харгалзан үзэх хэрэгтэй."³⁵ гэжээ.
- ХМДҮС нь уул уурхайн компаниудаас "Хаягдлын байгууламжийн ашиглалтын мөчлөгийн туршид мөн олон нийтийн аюулгүй байдал, хаягдлын байгууламжийн бүрэн бүтэн байдалд нөлөөлж болзошгүй шийдвэр гаргах бол төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг бодитой, утга учиртай оролцуулж, мэдлэгийн суурийг нь бүрдүүлж байгаагаа харуулахыг"³⁶ шаарддаг. **Энэхүү шаардлагыг биелүүлэхийн тулд ОТ нь ХХБ-ийн талаар малчид, олон нийтийг зохистой мэдээллээр хангаж, нэвчилт нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй талаар малчид, олон нийттэй зөвлөлдсөн гэдгээ харуулах ёстой.**

Ерөнхийдөө эдгээр стандартуудад шаардсанаар ОТ шүүрлээс **урьдчилан сэргийлэх** арга хэмжээ авч; шүүрлийн үед авах хариу арга хэмжээ, нөлөөллийг **бууруулах нарийвчилсан төлөвлөгөөтэй** байж; болзошгүй нөлөөллийг **мэдээлэх**, аливаа хор хөнөөлийг **арилгахын** тулд орон нутгийн иргэдтэй хамтран ажиллах ёстой. ОТ нь шүүрэлтийг тогтоох арга хэмжээ авах асуудалд нухацтай хандаж байгаа хэдий ч хаягдлын далангийн шүүрэлтээс үүдэлтэй нийгмийн эрүүл мэндэд учирч болзошгүй нөлөөллийг арилгахын тулд нэгдсэн хүчин чармайлт гаргах хэрэгтэй байна. Шүүрэлт гарч буйг илэрүүлснээс хойш малчдын ашигладаг усны эх үүсвэрт химийн ямар бодис нэвчиж орсон тухай мэдээлэл байхгүй дээр, шүүрэлтэд өртсөн газарт амьдарч буй малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах талаар арга хэмжээ аваагүй байна. ДААХТ-д хор судлалын үнэлгээг хийнэ, мөн хамгийн сүүлийн Ахиц дэвшлийн тайланд үнэлгээ нь удахгүй бэлэн болно гэж амласан хэдий ч уг үнэлгээний ажлын цар хүрээнд нэвчилтэд өртсөн усыг ашигладаг хүн, амьтны эрүүл мэндийн үнэлгээг оруулаагүй тул эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлж гаргах эсэх нь эргэлзээтэй байна³⁷. Нэмж дурдахад ОТ нь шүүрэлтийн талаар ард иргэдэд сэрэмжлүүлэг өгөхийг хойшлуулсан нь дээр дурдсан стандартын дагуу байгаль орчин, эрүүл мэндийн эрсдэлийг хянах, мэдээлэх төлөвлөгөөнд нь дутагдал, цоорхой байна гэдгийг илтгэнэ.

Ийнхүү эрсдлээс хамгаалах арга хэрэгслийг зохих ёсоор нэвтрүүлснийг баталгаажуулахын тулд ОТ-с энэ талаар авч буй хүчин чармайлтыг зээлдүүлэгчид илүү нарийн хянах хэрэгтэй. Шүүрэлтийг арилгахад чиглэсэн ОТ-н ДААХТ нь сайн эхлэл боловч иргэдийн итгэлийг эргүүлэн олж авахын тулд ОТ шүүрэлтээс гүний усанд учруулах эрсдлийг тогтмол хэмжиж, орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл учрахаас урьдчилан сэргийлэх шат дараалсан бодитой арга хэмжээ авах

³⁵ 2020, ХМДҮС, шаардлага 4.5, <https://globaltailingsreview.org/wp-content/uploads/2020/08/global-industry-standard-on-tailings-management.pdf>

³⁶ 2020 ХМДҮС, шаардлага 1.3.

³⁷ ХХБ-ийн ДААХТ-ний 2024 оны 3-р улирлын ахиц дэвшлийн тайлангийн 11-р зүйлд "Хор судлалын судалгаа (Үйл ажиллагаа 10) нь нэвчсэн усны цэвэрлэгээ ба түүний техникийн үзүүлэлтүүдийг хамрах болно." гэжээ. <https://admin.ot.mn/wp-content/uploads/Progress-Report-Q3-EN.pdf>

шаардлагуудыг хэрэгжүүлэх ёстой – ингэхдээ малчид, ялангуяа ХХБ-д хамгийн ойр нутагладаг хүмүүстэй илүү үр дүнтэй харилцах шаардлагатай болно.

Хүн, малын хэрэглэж буй уснаас илэрсэн химийн бодис, мөн уул уурхайн орчмын хөрс, биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг тогтоох зорилгоор хийсэн усны чанарын бие даасан судалгааг яаралтай нийтэд ил болгож, бохирдсон усыг шууд болон шууд бусаар буюу хүнсэнд хэрэглэж буй ургамал, малын махаар дамжин хэрэглэснээс малчдын эрүүл мэндэд гарсан өөрчлөлт, үүссэн эсхүүл үүсч болзошгүй өвчлөлийн эрсдлийг тогтоохын тулд **малчдыг мөн мал сүргийг нь эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулахыг ОТ-д зөвлөж байна.**

3. Талуудтай зөвлөлдөх үйл явцыг ОТ нь хангалттай хэмжээнд, утга учиртайгаар хийдэггүй, хаягдлын далангийн шүүрэлтийн тухай мэдээллийг ил тод байлгасангүй

ОТ нь ХД1-ээс шүүрэлт гарч байгаа тухай нутгийн малчдад мэдэгдэхийг хойшлуулснаар тэдний итгэлийг алдах үйлдлийг хийв. 2013 онд ашиглалтад орсноос хойш ХД1-ийн эргэн тойрны олон цэгт ус нэвчиж байгааг мэдэж, энэ тухай 2015 оны тайландаа тэмдэглэсэн ч шүүрэлтийг хааж байгаа хэмээн мэдэгдэж, аюулын түгшүүр зарлаагүй. 2019 оны 6-р сар гэхэд уурхайн лицензийн талбайн хилийн ойролцоо НУХБХ-ийн (TDS) түвшин нэмэгдсэн нь илэрч, шүүрэлт нүүж байгааг илтгэсэн ч шүүрэлт гарсныг ОТ 2021 оны 11-р сард л албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. Энэ тухайд нөлөөлөлд өртсөн ард иргэдэд зөвхөн нэг жилийн дараа буюу 2022 оны 9-р сард мэдэгдсэн ба нөлөөлөлд өртсөн олон малчдыг орхин уг мэдээллийг зөвхөн орон нутгийн засаг захиргаа болон ГТЗ-д л өгсөн байна³⁸.

ХД1-ийн шүүрлийг зохих ёсоор шийдвэрлэхийн тулд зээлдүүлэгчид өөрсдийн хөшүүргийг ОТ-д хэрэглэж, 2023 оны 12 сард Дутагдал Арилгах Арга Хэмжээний Төлөвлөгөө (ДААХТ) боловсруулахыг тэднээс шаардсан. 2024 оны 9 сард хийсэн томилолтын үеэр Аккаунтэбилити Коунсел ХХБ-д хамгийн ойр амьдарч буй 4 малчин өрхтэй очиж уулзахад тэдний хэн нь ч ДААХТ-ний талаар мэдээлэл аваагүй, уг төлөвлөгөөг боловсруулахад тэднийг оролцуулаагүй гэж байв. Малчид шүүрэлтийн цар хэмжээ, нөлөөллийн талаар юу ч мэдэхгүй, дам цуу яриа л сонсож байснаас ОТ-с зохих тайлбар аваагүй гэж байв. Харин нэг айлд ОТ-н ажилтан биеэр ирж, ‘шүүрэлтийг тогтоосон’ гэж мэдээлсэн ба ‘тогтоосон’ гэдэг нь яг юу гэсэн үг болохыг дэлгэрэнгүй тайлбарлаагүй ажээ.

ГТЗ дэх МТБ-ийн төлөөлөгчийн хэлснээр, ОТ хаягдлын ус нэвчсэнийг хүлээн зөвшөөрмөгц, хэд хэдэн (2-3) багийн айл өрхүүдэд очиж нөхцөл байдлын талаар мэдээлэл өгч, асуултуудад хариулсан гэдэг. Гэвч бидэнтэй ярилцсан нөлөөлөд өртсөн малчидын хэлснээр, мөн тэр дотроо 2024 оны 9-р сарын судалгааны үеэр очиж уулзсан малчдын хариулснаар, ОТ нь нөлөөлөлд өртсөн бүх малчдад хүрч ажиллаж чадаагүй байна. Ямар алдаа гарсан нь тодорхойгүй ч малчидтай харилцах нь хэт ховор, тогтмол бус, мэдээлэл нь техникийн үг хэллэгтэй байсан учраас малчдад бүрэн ойлгогдохооргүй байсан байж магадгүй. Нөгөө талаар ОТ нь айл болгонд хүрч ажиллаагүй байж болно. Энэ нь нөлөөлөлд өртсөн малчдыг илүү сайн тодорхойлох, мэдээллийг цаг алдалгүй, үр

³⁸ ОТ 2013 онд анх ашиглалтад орсноос хойш ХД1-ийн эргэн тойронд дор хаяж гурван цэгт нэвчилт үүссэнийг мэдэж байсан бөгөөд 2015 оны 4-р сарын 30-ны өдөр Голдер Ассошиэйтс-ын гаргасан ХХБ-ийн Raise зураг төслийн тайланд үүнийг баримтжуулан тэмдэглэсэн байна. 2019 оны 6-р сард уурхайн лицензит талбайн хил дээр ОТМВ 16-79 цооног дээр хяналт тавихад НУХБХ түвшин нэмэгдсэнийг ОТ тэмдэглэв. (2023 оны 9-р сарын ББОНЗ DWRR, ху. 2).

дүнтэй хүргэхийн тулд мэдээлэл хүргэх, солилцох олон төрлийн аргыг ашиглах шаардлагатай байгааг харуулж байна. Малчид нь малаа маллад ачаалалтай, завгүй ажилладаг тул харилцаа холбоо нь тэдний нөхцөл байдалд тохирсон байх ёстой.

Эдгээр уулзалтуулаар бид мөн ГТЗ-ийн талаарх малчдын төсөөлөл, ойлголтын тухайд илүү ихийг олж мэдсэн дээр, ОТ-н шууд нөлөөлөлд өртсөн малчидтай ярилцан тогтмол гардаг сорилт бэрхшээлүүдийн талаар ойлголттой болохыг зорин, мэдээлэл цуглуулав. ГТЗ нь мэдээлэл олж авах, шүүрэлт гэх мэт тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд зохимжтой талбар байж чадахаа больсонд санаа зовж байгаагаа малчид илэрхийлж байв. Малаа маллахад ихэнхи цагаа зарцуулдаг малчид мал сүргээ эн тэргүүнд тавьдаг тул ГТЗ-ийн хуралд тогтмол оролцох цаг зав хомс байдаг. Малчдын хөндсөн нэг ноцтой асуудал нь ГТЗ-ийн дүрэмд ГТЗ-ийн гишүүн бус хүмүүс хуралд саналаа хэлэх эрхгүй гэж заасан учраас малчид тулгамдаж буй асуудлаа эдгээр хурлууд дээр сөхөн ярих боломжгүй байдаг гэлээ³⁹. ОТ нь малчдыг тулгамдаж буй асуудлуудаар компанид шууд хандахаас сэргийлж ГТЗ-ээр дамжуулдаг болгосон гэж малчид хэлж байв. Тэд ГТЗ-д үл итгэх болсон нь илт. Харин ОТ-н зүгээс малчдад мэдээлэл өгөх, тэдэнтэй зөвлөлдөх үндсэн суваг нь ГТЗ гэдгийг бид анзаарлаа. Малчид тулгамдсан, чухал мэдээллийг авахгүй байгаагаас харахад мэдээллийн энэ суваг нь үүргээ биелүүлэхгүй байгааг малчин өрхүүдтэй хийсэн ярилцлагуудаас олж мэдлээ. Иймд ОТ мэдээлэх, зөвлөлдөх үйл явцыг өргөн хүрээнд ил тод болгож, малчин олон нийттэй шууд харилцаж, нэвчилтэд өртсөн хүмүүсийн тулгамдаж буй асуудлуудыг сонсож, шийдвэрлэхэд нь тус нэмэр болж байх шаардлагатай байна. ГТЗ нь хэзээ ч ОТ-н олон нийтийн зөвлөлдөх үйл ажиллагааг орлох зорилготой байгаагүй юм.

ОТ нь ЕСБХБ болон ОУСК-ийн хамгаалалтын шаардлагуудыг дагаж мөрдөхгүй, шүүрэлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийг бодитой оролцуулалгүйгээр шийдвэрүүдийг ганцаарчлан гаргасаар байна. Бохирдсон усыг өөрсдийн унданд болон малынхаа өдөр тутмын хэрэгцээнд ашиглаж буй малчдад мэдээллийг ил тод хүргэх нь маш дутмаг байна⁴⁰. **Дахин сануулахад, уурхайн хаягдлын далангийн шүүрэлт малчдын ашиглаж буй ус, бэлчээрт хэрхэн нөлөөлснийг ил болгох, нийт ууссан хатуу бодисын хэмжээ (НУХБХ) ихтэй далангаас доош шүүрсэн усыг хэрэглэж байгаа малчид болон тэдний малыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах шаардлагатай байна.**

Нэвчилт, шүүрэлт тойрсон гол тулгамдсан асуудлуудын талаар малчдаас асуухад тэд бэлчээр, ус, малчин ахуй амьдралдаа хамгийн их санаа зовж байна гэв. Зээлдүүлэгчид өөрсдийнх нь хамгааллын шаардлагууд, ялангуяа шүүрлийн асуудлыг шийдвэрлэх⁴¹, түүнчлэн уурхайн талбайн эргэн тойрны байгаль орчныг хамгаалах⁴² тухайд төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүстэй бодитойгоор зөвлөлдөн, тэднийг оролцуулж ажиллахыг

³⁹ Гурван талт зөвлөлийн дүрмийн гуравдугаар бүлэг, 2 дугаар зүйл, 2.1.9 дүгээр заалт, 2019 он.

⁴⁰ ХХБ-ийн шүүрлийн сангийн усны чанарын үзүүлэлтүүд нь Австрали Шинэ Зеландын Байгаль орчин, хамгаалах зөвлөлийн (ANZECC) Мал аж ахуйн усны нийт ууссан хатуу бодис, сульфат, фтор, молибден, бор, селенийн хэмжээ нь удирдамжаас давсан байна. НУХБХ нь тогтмол бус нэмэгдэж байгааг 2018 оноос хойш баримтжуулж байна. ХХБ-ийн шүүрлийн сангийн усан дахь НУХБХ концентраци нь ихэвчлэн ойролцоогоор 6,000-аас 8,000 мг/л хооронд хэлбэлздэг ба ХД1-аас доош нэвчсэн шүүрэлтийн усан дахь НУХБХ 21,557 мг/ хүртэл түвшинд бүртгэгдсэн байна. НУХБХ болон бусад химийн бодисууд ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас 300 метрийн зайд нэмэгдэж байгааг ББОНЗ -ийн тайланд дурдсан байна.

⁴¹ ОУСК Гүйцэтгэлийн стандарт 1 оноо 25-31. ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага 1 оноо 11, гүйцэтгэлийн шаардлага 10 оноо 27-30.

⁴² ОУСК Гүйцэтгэлийн стандарт 1 оноо 7-16, Гүйцэтгэлийн стандарт 3 оноо 4-6, 9-12. ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага 1 оноо 9-12, 29-33, гүйцэтгэлийн шаардлага 3 оноо 6-19.

ОТ-с шаардах ёстой. Зээлдүүлэгчдийн хамгааллын шаардлагуудыг ОТ дагаж мөрдөхийг хичээх төдий бус харин бодитой биелүүлэх цаг нь болсон⁴³.

Малчдыг учир утгатай татан оролцуулахын тулд **ОТ нь оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг (ОТОТ) мэдэгдэхүйц сайжруулах, чингэхдээ асуудлын хураангүйд одоогоор дурдагдаагүй шүүрлийн асуудал, удаашралтай хэрэжиж буй МГБГ-г нэмж оруулах хэрэгтэй**⁴⁴. ОТ нь ХХБ-ийн шүүрэлттэй холбоотойгоор Мэдээлэл, оролцооны төлөвлөгөөг ДААХТ-д тусгасан хэдий ч ХХБ-ийн ойролцоо нутагладаг бидний зочилсон малчин өрхүүд өнөөг хүртэл хангалттай мэдээлэлгүй, ДААХТ-ыг боловсруулахад бодитой оролцоогүй хэвээр байна. Энэ нь хаягдлын далангийн нэвчилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд талуудын оролцоо хангалтгүй байгааг харуулж байна.

Зээлдүүлэгчдийн хамгааллын шаардлагууд, олон улсын хамгийн өндөр стандартадуудыг мөрдөж ажиллахын тулд ОТ нь мэдээллийг нийтэд ил тод болгож, арга барилаа яаралтай сайжруулах шаардлагатай. Үүнд шүүрлийн мониторинг, хаягдлын далангийн удирдлага бүхий ДААХТ-ний хэрэгжилтийн шинэ мэдээллүүд, хавсралтуудыг монгол, англи хэлээр шуурхай хуваалцаж байх. 2024 оны 4-р сард ДААХТ анх нийтлэгдсэнээс хойш тайланд хавсаргагдсан гэх шаварлаг давхаргын туршилтын үр дүн, шүүрэлтийн үнэлгээ, токсикологийн судалгаа хийх санал зэрэг чухал мэдээлэлүүдийн нэг ч холбоос тавигдаагүй байна⁴⁵. Шүүрэлттэй холбоотой нөхцөл байдлыг бүрэн ойлгохын тулд эдгээр баримт бичгүүдийг сонирхогч бүх талуудад ил тод болгох нь нэн чухал дээр, эдгээр мэдээллийг талуудад ил тод дэлгэснээр ОТ нь шүүрэлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ нээлттэй, шударга хандаж байгааг харуулах болно. Мэдээллийг ил тод болгохгүй бол асуудлыг оновчтойгоор шийдвэрлэхэд нэмэрлэх үр дүнтэй шийдлүүд гарч ирэхгүй билээ. Зээлдүүлэгчдийн хамгаалалтын шаардлагуудын дагуу нөөлөөлөлд өртсөн олон нийтэд тайлагнахдаа ДААХТ-ний хүрээнд хийж буй ажлын талаар малчидтай зөвлөлдөж, малчдын санал бодлыг тусгаж байх хэрэгтэй⁴⁶.

Зээлдүүлэгчдэд буй мэдээлэл болон газар дээрх малчдын туршлага хоорондоо зөрүүтэй байгаа тул зээлдүүлэгчид мэдээллийн эх сурвалжаа өргөжүүлэн малчдын өргөн бүлгээс мэдээлэл авахыг зөвлөж байна. Зээлдүүлэгчдийн жил бүрийн айлчлалын үеэр малчидтай уулзалт зохион байгуулж, аудиторруудыг өргөн эх сурвалжуудаас оролцуулж, гадны оролцогч талуудтай хамтран ажиллах замаар өргөн хүрээний хэтийн төлөвийг багтаасан, дүн шинжилгээг зөвхөн нэг талын мэдээллээс хамаарахгүй байх замаар хийхийг зөвлөж байна.

4. Малчдын амьжиргаагаа залгуулдаг бэлчээр, усны нөөцийг хамгаалах боломж ОТ-д бий

Хүрээлэн буй байгаль орчин нь он удаан жил эрүүл байх явдал малчдын хувьд эн тэргүүний асуудал гэдгийг тэд хэлж байв. ОТ-той олон жилийн турш хөршлөн орших болно гэдгээ малчид ухамсарлаж байгаа бөгөөд байгаль орчинд хор хөнөөл

⁴³ 2024 оны 9-р сард Улаанбаатар хотод ОУСК, ЕСБХБ, EDC-тэй хийсэн уулзалтад зээлдүүлэгчид ОТ нь нийцлийг хангаж ажиллахыг хичээж байгаа гэв. Энэ нь хангалттай биш юм. Зээлдүүлэгчдийн үйлчлүүлэгчид орон нутгийн иргэд болон байгаль орчинд хор хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэхийн тулд өөрсдийн хамгаалалтын зарчмуудыг мөрдөж, нийцлийг хангаж ажиллах ёстой.

⁴⁴ Оюу Толгойн БОННУ 2012, БҮЛЭГ D14: ОРОЛЦОГЧ ТАЛЫГ ОРОЛЦУУЛАХ БАРИЛГЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ху. 20-22

⁴⁵ Оюу толгой Дутагдал Арилгах Арга Хэмжээний Төлөвлөгөө, 2-р улирал, 2024 оны 7-р сар.

⁴⁶ ОУСК Гүйцэтгэлийн стандарт 1 оноо 36. ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 10 оноо 6-9, 27-30.

учруулалгүй, говийн нөөцийг тогтвортой удирдах замаар орон нутгийн иргэдтэй харилцаа холбоогоо эрхэмлэхийг малчид ОТ-с хүсч байна. Мал маллаж аж төрөхөд гол нөөц болдог бэлчээр газар, ундны ус нэгэнт хомсдоод байна. ОТ анх энэ нутагт орж ирмэгцээ олон малчин өрхийг өвөг дээдсийнх нь нутаг бэлчээрээс нүүлгэсэн. Зарим айл өрх мал маллахаа болихоос өөр сонголтгүй болсон бол зарим нь бусадтай бэлчээр хуваалцахаас өөр аргагүй болсноор бэлчээрийн даац хэтэрч, өрх хооронд бэлчээрийн маргаан гарсаар байна. Малчдыг уламжлалт бэлчээрээс нь нүүлгээд барахгүй гол хоёр байгалийн нөөц болох Дугат Халив, Ундай голуудын гольдролыг шилжүүлэв. Уурхайн урд талын Ундай голын урсгалын чиглэлийг амжилттай өөрчилсөн ч Дугат Халив голын хувьд ийм нарийн төлөвлөлт хийгдээгүй, ОТ-н ХХБ нь Дугат-Халив голын сав газарт байрлаж байна. ХД1 ба ХД2-ыг барихын тулд ОТ нь ХХБ-ийн эргэн тойронд гадаргын усыг зөөвөрлөх суваг шуудуй барих шаардлагатай болсон. Энэ нь малчдын янз бүрийн цэгээс ус авах боломжийг хязгаарласан.

Мөн ОТ шүүрэлтийн бохирдлын улмаас Дугат Халив голын гадаргын урсацыг ХХБ-ийн талбай руу эргүүлэн даялуулж, шүүрэлтээс үүдэх болзошгүй бохирдлыг хязгаарлах арга хэрэглэсэн⁴⁷. Өөрөөр хэлбэл, голын дагуу, ХХБ-ийн доод хэсэг руу нутагладаг малчдад хүрэх ёстой байсан усыг малчдад хэлэлгүйгээр эргүүлэн авч, малчдын усан хангамжид аюул учруулсан⁴⁸.

Аккаунтэбилити Коунселын 2023 оны 7-р сард хийсэн томилолтын ажлын тайланд уурхайн доод хэсэг руу орших Будаа, Байшинт, Улаан хошуу, Буурал зэрэг 4 булгийн усны нөөцөд өөрчлөлт гарсныг тогтоосон. 2024 оны 9 сард ОТ-н уурхайн талбайд очиход тухайн үед (биднийг очихоос өмнөхөн) хур тунадас ихтэй байсан учраас Будаа, Байшинтын булаг ус ихтэй байв. Уг газарт нутаглан, малаа малласаар ирсэн малчид хэлэхдээ өмнө нь эдгээр булаг шанд бүтэн жилийн турш дүүрэн устай байдаг байсан бол өдгөө түр зуурын шинжтэй, бороо хуртай үед л урсдаг болсон гэж байлаа. Эдгээр булгийг байнгын устай булаг шанд биш, түр зуурын шинжтэй булаг хэмээн үзээж ОТ-н суурь судалгаанд хамруулаагүй гэж ОТ-н нэг ажилтан хэлсэн. ОТ малчдын амьдралын туршлага, арвин мэдлэгийг үл тоомсорлон, олон зуун жилийн турш ашиглаж ирсэн чухал булаг шандыг тодорхойлох суурь судалгааг гаргахдаа нутгийн малчидтай зөвлөлдөөгүй нь үүгээр харагдана. Ийм хандлага нь малчдын ОТ-д үл итгэх байдлыг улам ихэсгэж байна.

Өөр нэг асуудал бол голын гольдролыг өөрчлөх сувгийг их хэмжээний борооны усыг тогтоох, их хур тунадас унасны дараа усны урсацыг даах чадавхигүй барьсныг хэд хэдэн газар гол үерлэхсэн байгаагаас харах боломжтой байв. Голын гольдролыг өөрчлөх одоогийн өөрчлөлтийн шуудуу нь онолын хувьд гадаргын урсацыг ХД2-ын хилийг тойруулан, доод хэсэг руу урсах байгалийн гольдрол руу оруулах ёстой. Харамсалтай нь одоо байгаа өөрчлөлтийн шуудуу үерийн их урсгалыг багтаахаар хангалттай том биш бөгөөд шуудуу үерт автаж, Дугат Халивын ус ХД2-ын орчимд тогтсон байсныг бид харсан.⁴⁹ Хэдийгээр үер байнга болоод байдаггүй ч үүнийг урьдчилан таамаглах боломжтой.

⁴⁷ “ОТ нь [2022 оны 9-р сар] гэхэд босоо чулуулгийн уруудмал хэсэгт байрлах Дугат Халивын гадаргын усны гольдролоос усыг нь шахаж, цуглуулсан усыг ХХБ-руу чиглүүлж эхэлсэн. Энэхүү ус нь ХХБ-ийн нэвчилт болон ХД1-ээс үерийн усны урсацыг холдуулан гольдиролыг өөрчилсөн Дугат Халивын гадаргын хуримтлагдсан усны холимог байх магадлал өндөр.” 2023 оны 9-р сарын ББОНЗ-ийн Усны нарийвчилсан үнэлгээний тайлан, ху. 2.

⁴⁸ 2023 оны 9-р сарын ББОНЗ-ийн Усны нарийвчилсан үнэлгээний тайлан, ху. 9.

⁴⁹ “2023 оны 7-р сарын 28-нд их хэмжээний хур тунадас орж, энэ системээр их хэмжээний ус шилжсэн. ХХБ-ийн 2-р далангийн барилгын ажилд оролцож буй гүйцэтгэгч Дугат Халив голын гадаргын усны гольдролын хэсгийг дүүргэж, шуудуу дээгүүр машин нэвтрэх боломжийг олгосон. Энэхүү хаалт нь ХХБ-ийн 1-р хаягдлын далан ба босоо чулуулгийн хоорондох шүүрэлт цуглуулах хэсэг рүү их хэмжээний усыг

Малчдад нэн чухал үүрэг гүйцэтгэдэг Дугат-Халив голын бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд ОТ нь Дугат Халив голын гольдролыг өөрчлөх, их хэмжээний үерийг даван туулах хүчин чадалтай байнгын суваг шуудуу барих ёстой. Уур амьсгалын хэв шинж өөрчлөгдөж, хур тунадасны хэмжээ ихсэх тусам Монгол оронд борооны улирлын үеэр өмнөх цаг үеэс илүү их үер буух магадлал өндөр байна. Одоогийн байдлаар ОТ голын гольдролыг өөрчлөх сувгийн асуудлыг шинээр суваг⁵⁰ барьж шийдэх гэж байгаа бөгөөд ирээдүйд болох үерийн магадлалыг хүлээн зөвшөөрч, аль болох их хэмжээний үерийн усыг багтаан урсгах хүчин чадал бүхий суваг барихыг малчид ОТ-с хүсч байна. Гольдрол даялуулах шуудуу нь үргэлжилсэн их бороо, үер усны үед ч голын урсацыг даялуулах хүчин чадалтай гэдгийг малчид, зөвлөхүүдэд баталгаажуулах үүднээс бид урьдчилсан зураг төсөл, тооцоололтой танилцахыг хүсч байна.

Голын гольдрлыг өөрчлөх шинэ суваг барих ажилд нэмэлт хүндрэл үүсгэх ОТ-н бас нэг төлөвлөгөө бол ОТ уурхайн лицензит талбайг өргөтгөж, ХД2-ыг дүүрэхээр арав хүртэлх жилийн турш ашиглах хоёр хаягдлын далан шинээр барихаар төлөвлөж буйг бид мэднэ. Эдгээр нь малчдын бэлчээрээс багадаа гэхэд найман шоо дөрвөлжин километр талбайг авна. Үүнээс гадна хаягдлын далангийн нэг нь одоо төлөвлөж буй ДХ голын өөрчлөлтийн сувгийн яг дээр нь байрлахаар байгаа ба усны энэхүү чухал эх үүсвэрийг дахин эрсдэлд оруулснаар гольдрол даялуулах бас нэг сувгийг аравхан жилийн дотор дахин барих шаардлага гарна. Энэ нь байгаль орчин, малчдад илүү их сөрөг нөлөө учруулахуйц туйлын үр ашиггүй шийдвэр юм.

Уг өргөтгөлийн төлөвлөгөөний дагуу ОТ нь Дугат Халив гол руу нэвтрэх малчдын боломжийг ямар ч шаардлагагүйгээр эрсдэлд оруулахаас гадна үлдсэн бэлчээрээс нь илүү их газрыг мөн л ямарч шаардлагагүйгээр авах гэж байна.

Малчдад мэдээлэл олж авах, санаа зовоосон асуудлаа илэрхийлэх, ХХБ-ийн төлөвлөлтөд оролцох боломжийг хангах нь олон улсын шаардлагын гол бүрэлдэхүүн хэсэг билээ⁵¹. Малчдад шууд нөлөөлөл учруулж буй уурхайтай холбоотой бүх асуудлаар малчидтай бодитойгоор зөвлөлдөх явдал чухал төдийгүй бүрэн хэмжээний өөрчлөлтийн сувгийг одоо бариад 20 жилийн дараа түүнийгээ ХД4-ийн дор булаад өөр нэг өөрчлөлтийн сувгийг дахин барих нь ОТ-н хувьд оновчгүй, үр ашиггүй гэж бид үзэж байна. Уурхайн ашиглалтын үлдсэн хугацаанд ашиглах боломжтой, үер ус тогтоох дээд зэргийн хүчин чадалтай, томоохон нэг сувгийг зохих ёсоор барьвал илүү ухаалаг, оновчтой бөгөөд малчид, байгаль орчинд эрсдэл, аюул багатай хувилбар юм. **Малчдын амьжиргаа, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг аль болох багасгаж, ирээдүйд баригдах хаягдлын байгууламжуудын менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа нутгийн малчидтай зохих ёсоор зөвлөлдөхийг ОТ-д уриалж байна.**

(50,000 м3 гэж тооцоолсон) чиглүүлэхэд хүргэсэн." - Усны нарийвчилсан үнэлгээний тайлан, 2023 оны 9-р сарын 27, ху. 12-13. Мөн "ХХБ-ын 2-р далангийн барилгын ажилд ашигласан шавар нүхэнд хуримтлагдсан үерийн усыг байгаль орчны хяналтын протокол журмыг зөрчин Дугат Халив голын гадаргын усны суваг руу шууд урсгасан. Энэ нь байгаль орчны осол гэж албан ёсоор тооцогдоогүй ч осол болсонд тооцогдож болох байсан." Усны нарийвчилсан үнэлгээний тайлан, 2023 оны 9-р сарын 27, ху. 7.

⁵⁰ Бид 2024 оны 9-р сард уурхайд зочлохдоо Дугат Халив голын гольдролыг өөрчлөх сувгийг байрлуулах шинэ замыг ажиглав. Гэвч энэ байгууламжийг 2026 он хүртэл хойшлуулсан гэдгийг ОТ мэдэгдэв.

⁵¹ Жишээ нь, ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 1-д: "Төслөөс үүдэх тодорхойлогдон тогтоогдсон эрсдэл, сөрөг нөлөөлөлд олон нийт өртсөн тохиолдолд үйлчлүүлэгч төслийн эрсдэл, нөлөөлөл, нөлөөллийг бууруулах арга хэмжээ авах талаар санал бодлоо илэрхийлэх боломжоор нөөлөөлөлд өртсөн олон нийтийг хангасан байдлаар зөвлөлдөх үйл явцыг өрнүүлж, тэдгээрийг бодолцон, хариу өгөх боломжийг үйлчлүүлэгчид олгоно."

Бидний санал болгож байгаа зөвлөлдөх үйл ажиллагааг хийхийн тулд ОТ хаягдлын менежментийн ирээдүйн төлөвлөгөөгөө эргэн харах шаардлагатай бөгөөд үүнд цаг хугацаа, нөөц шаардагдна гэж ойлгож байна. Гэхдээ урт хугацаандаа бэлчээр нэмж авахгүйгээр, хаягдлыг хариуцлагатай хадгалах арга замыг хайж олох нь илүү үр ашигтай, зардал багатай байх болов уу гэж бодож байна. ОТ-н удирдлагын баг, ХХБ-ийн удирдлагын багтай хийсэн уулзалтын үеэр **ирээдүйн хаягдлын менежментийн өөр нэг хувилбарыг бид санал болгосон нь одоогийн ХД5, ХД6-г барихаар төлөвлөж буй газар ХД3 ба ХД4-ийг төлөвлөж, өөрчлөн зохион байгуулах юм.** Ингэснээр малчид илүү их бэлчээр газраа алдахаас сэргийлж, ОТ нь уурхайн лицензитай газраа илүү үр ашигтайгаар ашиглах юм. Хэдийгээр энэ стратеги нь асуудалд нэмэлт анхаарал хандуулахыг шаардах ч ХД3, ХД4-ийг барих хүртэл ОТ-д хангалттай хугацаа байна. Малчид газар нутагтайгаа хүйн холбоотой байдгийг санаж, ОТ нь малчдын амьжиргаа, хүний эрхэд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээнээ ухамсарлаж, эдгээр бусад хувилбаруудыг харж үзэхийг ОТ-д уриалж байна.

Эцэст нь, 2024 оны 9 сард болсон Усны үр ашгийн семинарын үеэр ОТ болон РТ-н ажилтнуудаас гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлснээр ОТ үнэ цэнтэй усны нөөцийг хэмнэх боломжтой болно. Энэ семинарт оролцогчид уурхайн үйл ажиллагааны төрөл бүрийн асуудлууд, тэр дундаа хаягдлын менежментийн асуудлуудыг сайжруулах замаар усны хэрэглээг хэрхэн оновчтой болгох тухай ярилцсан. Одоогоор ОТ нь хаягдлынхаа сан дахь уснаас секундэд дунджаар 300 литр усыг ууршуулж алддаг. Усны хэрэглээг оновчтой болгосноор ОТ нь 100 литр усыг ууршуулалгүй хэмнэж болох ба үүнийг мөнгөн дүнгээр илэрхийлбэл нэлээд их тоо гарна. Семинараас гарсан зарим зөвлөмжүүд:

- **Хаягдлыг 64% өтгөрүүлснээр усыг хаягдлын даланд хүрэхээс өмнө дахин боловсруулах зорилгоор цуглуулах боломжийг олгоно** (дээр дурдсан болно). Үүнийг боломжтой болгохын тулд гурав дахь өтгөрүүлэгчийг худалдаж авах хэрэгтэй гэдэг дээр семинарт оролцогчид санал нэгдэв. Энэхүү өөрчлөлт нь хаягдлын далангаас шүүрэл гарахаас сэргийлэх учир малчид энэхүү зөвлөмжид тэргүүлэх ач холбогдол өгч байна.

- **ХД2-ын хаягдлыг оновчтой хуваарилан байршуулах:** энэхүү зөвлөмж нь ууршилтыг бууруулахад чиглэсэн энгийн өөрчлөлтүүдийг багтаасан болно. Жишээ нь, далангийн ханын налууг 2%-р нэмснээр далангийн нэг ирмэгийн дагуу усыг урсган цуглуулаад буцаах боломжтой болгох, мөн хаягдлыг бүхэлд нь жигд хуваарилахын тулд хаягдал дамжуулах хоолойнуудыг далангийн периметрийн дагуу илүү олон байршилд суурилуулах.

- **Далан хоорондын буюу олон далант ажиллагаа:** энэ нь хаягдлыг ХД1-ээс ХД2 руу шилжүүлэхийг хамарна. Эхний алхам бол өмнө нь шингэсэн усыг сэргээх боломжийг олгохын тулд идэвхгүй ХХБ1-д цооног худгийн ус зайлуулах системийг суурилуулах; дараа нь зайлуулсан усыг ХД2-т шилжүүлж улмаар баяжуулах руу буцаах. Мөн ОТ нь хаягдлын ууршилтыг бууруулж, нягтралыг сайжруулахын тулд хаягдлын далан бүрийг олон даланд хуваах замаар ус хэмнэх боломжтой.

- **Хаягдлын урсгалыг ялгах:** хуурай хаягдлын бүрдэл хэсгүүдийг (элс) нойтон хаягдлын бүрдэл хэсгүүдээс (лаг) салгаж, тус тусад нь хаях систем бөгөөд ингэснээр лагийн фракц, хэмжээг оновчтой болгох боломжтой юм.

- **Нуруулдан уусгах:** энэ нь ОТ-д одоо ашиглаж буй өтгөрүүлсэн хаягдлын үйл ажиллагаанаас ялгаатай хуурай хаягдлын систем юм. Үүнд ОТ-ийн өтгөрүүлсэн хаягдлын үйл ажиллагаанд ашиглаж байгаа флокулянтуудтай төстэй химийн бодис (флокулянт) ашиглан үнэт хүдрийг хаягдлаас нь ялгаж авна, чингэхдээ хамаагүй бага ус хэрэглэнэ. Энэ өөрчлөлтийг нэвтрүүлвэл одоогийн системийг шинэчилж, дээр дурдсан олон зөвлөмжийг дагах шаардлагагүй болно.

Ус ашиглалтын үр ашгийг сайжруулснаар говийн усны үнэт нөөцийг хэмнэхээс гадна ОТ нь нөөцийн хамгийн дэвшилтэт удирдлага бүхий уул уурхайн компани гэдгээрээ имиж, нэр хүндээ бэхжүүлэх болно.

5. Зөвлөмжүүд

Юуны өмнө бид ОТ-н удирдлагын баг эдгээр болон ирээдүйд гарч болзошгүй асуудлыг шийдвэрлэхэд тусгайлан зориулсан орон зайтай байхын тулд малчдын төлөөлөлтэй идэвхтэй яриа хэлцлийг хийх явдалд тэргүүн ач холбогдлыг үргэлжлүүлэн өгч байхыг зөвлөж байна. Биднийг Улаанбаатарт байх үед хатагтай Лигенфельдер биднийг нээлттэйгээр хүлээж авч уулзсанд ихэд талархаж байгаа бөгөөд малчид болон ОТ-н хоорондын харилцааг цаашид бэхжүүлэх, малчдын төлөөлөлтэй шууд уулзалтууд зохион байгуулж байх, тэр дундаа олон улсын зөвлөхүүдийн баг газар дээр очиж танилцах үеэр ч малчидтай уулзаж зөвлөлдөж байх боломж гарч байгааг баяртай хүлээн авч байна.

Үүнээс гадна ОТ, мөн тус компанийн санхүүжүүлэгчид орон нутгийн иргэдийн эрхийг хүндэтгэх амлалтаа биелүүлэхийн тулд авах ёстой зарим арга хэмжээний талаар саналуудаа үүгээр хүргүүлж байна. Үүнд:

1. МГБГ-ийг цаг тухайд нь бүрэн хэрэгжүүлэх

- a. МГБГ-ийн хэрэгжилтийн албан ёсны хяналтын системийг боловсруулж, нийтэд нээлттэй болгож, малчдад мониторинг хийх боломжийг олгон цаг тухайд нь хэрэгжилтийн мэдээллээр баяжуулж байх.
- b. Малчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлөх МГБГ-ийн хэрэгжилтийн удаашралаас сэргийлэхийн тулд МГБГ-ийг бүрэн хэрэгжүүлэх шинэчилсэн цаг хугацааг яаралтай гаргах.

2. Хаягдлын далангийн шүүрэлтийг зогсооход чиглэсэн арга хэмжээг сайжруулах

- a. Шүүрэлт уурхайн талбайгаас гадагш хэр хол тархсан, түүнд химийн ямар бодис, металл агуулагдаж байгаа, орон нутгийн байгаль орчин, хүн, амьтанд ямар нөлөө үзүүлж байгаа, цаашид ямар нөлөө гарагах вэ гэдгийг ойлгож мэдэхийн тулд шүүрэлтийн нөлөөллийн хараат бус үнэлгээг нийтэд даруй ил болгох.
- b. Шүүрэлтийн бохирдлоос үүдэлтэй аливаа хор уршгийг цаг тухайд нь илрүүлж, шийдвэрлэхийн тулд малчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад туслалцаа дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө боловсруулах.
- c. ХД1-ийн зураг төсөлд төлөвлөсний дагуу хатуулгийн агууламжийг 64%-д хүргэж (жишээ нь гурав дах өтгөрүүлэгчийг худалдан авах замаар), ХХБ-ийн үйл ажиллагааг бүхэлд нь олон улсын стандартад нийцүүлэхийн тулд (жишээ нь усыг буцаан хэрэглэх цөөрмийн системийг сайжруулах байдлаар) тодорхой ажлууд төлөвлөж эхлэх.
- d. Өмнийн говьд усны алдагдлыг бууруулахын тулд 2024 оны 9 сард болсон Усны үр ашгийн семинараас гаргасан 6 гол зөвлөмжийг яаралтай хэрэгжүүлэх.

3. Олон нийтэд хүрч ажиллах, бодитой, утга учиртай зөвлөлдөх ажлыг сайжруулах

- a. Шүүрэлттэй холбоотой эрүүл мэнд, аюулгүй байдлын чухал мэдээллийг үнэн зөв хүргэхийн тулд орон нутгийн малчдад хүрч ажиллах, мэдээлэл, харилцааны стратегийг сайжруулах.
- b. Хамааралтай бүхий л баримт бичиг, тайлан зэрэг амин чухал мэдээллийг ГТЗ-өөр хязгаарлагдахгүйгээр талуудтай монгол, англи хэлээр цахимаар хуваалцах.
- c. Утга учиртай зөвшилцлийг буй болгохын тулд Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөөг сайжруулж, хэлэлцэх асуудлуудын хураангүйд хаягдлын далангийн шүүрэлтийн асуудал, МГБГ-ийн хэрэгжилт удаашралтай байгаа асуудлуудыг оруулж, шийдвэрлэх.
- d. Ус хэмнэх богино болон урт хугацааны боломжуудыг судлах, ашиглах зорилгоор жил бүр Усны үр ашгийн семинарыг зохион байгуулах.

4. Малчдын амьжиргааг хамгаалах үүднээс бэлчээр, усыг хамгаалах

- a. Уурхайн лицензит талбайн гадна баригдах ХД3, ХД4-ийн төлөвлөгөөг өөрчилж, ОТ-н олборлолтын талбайн дотор байрлахаар төлөвлөгдсөн ХД5, ХД6-ын талбай руу шилжүүлэх.
- b. Дугат Халив голын бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тулд их хэмжээний үерийг даван туулах хүчин чадалтай урсгал өөрчлөх байнгын суваг шуудуу барих.

5. ОТ нь ХД1-д гарсан бүх сургамжийг авч, ХД2-г ажиллуулахдаа ижил алдаа гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.

6. ОТ нь хамгаалалтын нийцлийг хангаж ажилласнаа нотлохоос өмнө зээлдүүлэгчид нэмэлт санхүүжилтийг ОТ-д олгохгүй байх.